



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 23 өдөр

Дугаар А/543

Ховд

Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.2-ийн “б”, Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.6, Засгийн газрын 2018 оны 317 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүрмийн 3.1.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай 78 дугаар зүйлийн 78.2.4, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2017 оны 87 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Хаш өргөө” ХХК-ний хийж гүйцэтгэсэн Сургуулийн спорт заалын барилга /Ховд, Дуут сум/-ын ажлыг ашиглалтад оруулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:

З.Өмиртай

-Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын Барилга, хот байгуулалтын хэлтсийн дарга

Гишүүд:

Б.Түмэндэмбэрэл

-Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн ахлах мэргэжилтэн

Ш.Мөнхзаяа

- Мэргэжлийн хяналтын газрын эрчим хүчний хяналтын Улсын байцаагч

А.Ганцоож

- Мэргэжлийн хяналтын газрын Байгаль орчны хяналтын улсын байцаагч

Б.Бат-оюун

- Мэргэжлийн хяналтын газрын харилцаа холбооны хяналтын Улсын байцаагч

- А.Энхбаяр - Дуут сумын Засаг дарга
- Г.Энхбадам -Дуут сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирал
- Д.Очирбадам - Онцгой байдлын газрын Гал түймрийн Хяналтын Улсын ахлах байцаагч
- Б.Баяржаргал -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын Барилга хот байгуулалтын хэлтсийн мэргэжилтэн
- С.Батдорж -Аймгийн архивын тасгийн дарга
- Э.Алтан-Од -Барилгын зураг төслийн “Алтан орд констракш” ХХК-ний захирал
- П.Буянжаргал -“Ховдын хаш өргөө” ХХК-ний захирал
- Нарийн бичгийн дарга:
Б.Жамбалдорж -Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн

2.Сургуулийн спорт заалны барилгын ажлыг зураг, төсвийн дагуу шалгаж хянан баталгаажуулж шийдвэр гаргахыг комиссын дарга /З.Өмиртай/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ